БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## БАЯНГОВЬ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/16/СТА-ТШ3

| | |
|---|---|
| Баянхонгор<br>2021 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням<br>Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Глобал капитал аудит ХХК-ны Аудитор: Д.Энхтуяа<br>Утас: 99449299 Цахим хаяг: enhtuya@gmail.com |

005 ТӨРИЙН АУДИТЫН

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДУГН...

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ........ 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 10

3. Аудитын тайлан ........ 10

3.1. Ерөнхий зүйл 10

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй 11

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт 11

3.4. Материаллаг байдал 11

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд 12

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт 13

3.7. Шилэн дансны мэдээлэл 14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15

3.9. Аудитын илрүүлэлт 15

Залруулсан алдаа 15

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал 15

**Менежментийн захидал** ........ 15




005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02. 25 № 2/90

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНГОВЬ
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГАНСМАА ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн БСУГ, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнасан байна.

Тус байгууллага нь Ковид-19 цар тахлын онцгой дэглэмийн үед Аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 50,168,424.28 | 60,692,415.12 |
| 33 | АВЛАГА | 893,071.00 | 1,520,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 893,071.00 | 1,520,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 49,275,353.28 | 59,172,415.12 |
| 354 | Хангамжийн материал | 49,275,353.28 | 59,172,415.12 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,088,200.00 | 1,497,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 43,724,033.28 | 53,359,715.12 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,335,000.00 | 2,335,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 889,520.00 | 58,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 238,600.00 | 1,921,600.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 95,762,583.03 | 1,314,174,725.77 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 95,762,583.03 | 1,314,174,725.77 |
| 392 | Биет хөрөнгө | 91,832,583.03 | 1,310,244,725.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 62,410,672.00 | 1,287,560,555.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -3,388,502.28 | -34,065,670.87 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 24,144,477.55 | 40,779,653.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -14,048,575.87 | -17,977,155.47 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,808,048.00 | 40,929,152.75 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15,281,451.37 | -23,169,724.49 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 14,850,215.00 | 14,850,215.00 |
| 39217 | Ном | 1,337,700.00 | 1,337,700.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 3,930,000.00 | 3,930,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,930,000.00 | 3,930,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 145,931,007.31 | 1,374,867,140.89 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 145,581,583.61 | 1,374,867,140.89 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 145,581,583.61 | 1,374,867,140.89 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 39,887,287.00 | 39,887,287.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 39,887,287.00 | 39,887,287.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 55,822,336.81 | 1,285,107,894.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 55,822,336.81 | 55,822,336.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,229,285,557.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 49,871,959.80 | 49,871,959.80 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 145,931,007.31 | 1,374,867,140.89 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨВЛӨЛГӨӨ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,470,233,741.16 | 1,579,807,903.05 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,225,739,641.16 | 1,260,126,164.05 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,225,739,641.16 | 1,260,126,164.05 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,225,739,641.16 | 1,260,126,164.05 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,225,739,641.16 | 1,260,126,164.05 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 26,488,100.00 | 56,932,139.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 218,006,000.00 | 262,749,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 23,539,739.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 23,539,739.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 25,938,100.00 | 33,392,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,938,100.00 | 33,392,400.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 230,255,288.35 | 350,522,345.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 230,255,288.35 | 350,522,345.77 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 228,160,609.35 | 308,299,248.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 138,392,843.64 | 180,750,213.00 |
| 210101 | Үндсэн цалин | 138,392,843.64 | 180,750,213.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 18,168,505.40 | 27,780,735.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,546,089.40 | 22,247,429.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,496,767.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 494,345.00 | 1,121,206.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 128,071.00 | 242,591.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 2,672,742.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,841,340.00 | 32,087,541.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,091,315.00 | 537,741.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,420,025.00 | 31,219,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 330,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,906,800.00 | 4,313,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 908,850.00 | 2,258,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,226,650.00 | 1,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 435,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 120,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 30,619,280.00 | 20,226,138.16 |
| 210502 | Хоол, хүнс | 30,324,180.00 | 19,326,320.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 295,100.00 | 899,818.16 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 308,000.00 | 112,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 308,000.00 | 112,000.00 |


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,130,000.00 | 415,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,080,000.00 | 165,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 50,000.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,793,840.31 | 42,614,021.31 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 120,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,793,840.31 | 42,494,021.31 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,094,679.00 | 42,223,097.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 83,000.00 | 23,664,739.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 18,991,061.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 4,548,678.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 83,000.00 | 125,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 260.00 | 304,859.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 260.00 | 304,859.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,011,419.00 | 18,253,499.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,011,419.00 | 18,253,499.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,239,978,452.81 | 1,229,285,557.28 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,238,996,347.28 | 1,229,285,557.28 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 243,944,100.00 | 319,681,739.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 243,944,100.00 | 319,681,739.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 218,006,000.00 | 262,749,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 23,539,739.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 23,539,739.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 25,938,100.00 | 33,392,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,938,100.00 | 33,392,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 243,944,100.00 | 317,681,739.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 243,944,100.00 | 317,681,739.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 241,849,421.00 | 275,458,642.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 140,404,717.00 | 187,104,222.00 |
| 210101 | Үндсэн цалин | 120,289,908.00 | 119,043,645.99 |
| 210102 | Нэмэгдэл | 9,580,110.00 | 54,759,812.09 |
| 210104 | Урамшуулал | 10,534,699.00 | 13,300,763.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,770,464.00 | 20,838,679.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРӨЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,533,005.00 | 14,626,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,370,100.00 | 1,539,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 991,077.00 | 1,285,979.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 274,100.00 | 307,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,602,182.00 | 3,078,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,937,840.00 | 32,087,541.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,091,315.00 | 537,741.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,516,525.00 | 31,219,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 330,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,162,500.00 | 3,563,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 687,500.00 | 113,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 940,000.00 | 1,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 435,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 250,000.00 | 62,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 315,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,105,000.00 | 1,137,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 36,658,400.00 | 23,661,300.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,000.00 | 1,858,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,994,400.00 | 18,539,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,625,000.00 | 3,262,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,528,000.00 | 4,712,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,900,000.00 | 2,520,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,128,000.00 | 2,192,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 56,000.00 | 112,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 56,000.00 | 112,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 389,600.00 | 1,144,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 189,600.00 | 894,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 941,900.00 | 2,235,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 941,900.00 | 2,235,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,094,679.00 | 42,223,097.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 83,000.00 | 23,664,739.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 18,991,061.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 4,548,678.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 83,000.00 | 125,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 260.00 | 304,859.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 260.00 | 304,859.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,011,419.00 | 18,253,499.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,011,419.00 | 18,253,499.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 2,000,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 2,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 2,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 2,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 2,000,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | -2,000,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 39,887,287.00 | 49,871,959.80 | 55,822,336.81 | 00.00 | 145,581,583.61 |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 39,887,287.00 | 49,871,959.80 | 55,822,336.81 | 00.00 | 145,581,583.61 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 39,887,287.00 | 49,871,959.80 | 55,822,336.81 | 00.00 | 145,581,583.61 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,229,285,557.28 | 00.00 | 1,229,285,557.28 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 39,887,287.00 | 49,871,959.80 | 1,285,107,894.09 | 00.00 | 1,374,867,140.89 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 296,142,000.00 | 277,583,642.00 | 18,558,358.00 | 93.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 296,142,000.00 | 277,583,642.00 | 18,558,358.00 | 93.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 296,016,400.00 | 277,458,642.00 | 18,557,758.00 | 93.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 200,149,300.00 | 187,104,222.00 | 13,045,078.00 | 93.5 |
| 210101 | Үндсэн цалин | 117,291,100.00 | 119,043,645.99 | -1,752,545.99 | 101.5 |
| 210102 | Нэмэгдэл | 54,815,300.00 | 54,759,812.09 | 55,487.91 | 99.9 |
| 210104 | Урамшуулал | 26,042,900.00 | 13,300,763.92 | 12,742,136.08 | 51.1 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,000,000.00 | 00.00 | 2,000,000.00 | 0.0 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨВЛӨМЖ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,018,700.00 | 20,838,679.00 | 4,180,021.00 | 83.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,395,800.00 | 14,626,800.00 | 2,769,000.00 | 84.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,905,700.00 | 1,539,500.00 | 366,200.00 | 80.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,524,500.00 | 1,285,979.00 | 238,521.00 | 84.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 381,200.00 | 307,500.00 | 73,700.00 | 80.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,811,500.00 | 3,078,900.00 | 732,600.00 | 80.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32,392,400.00 | 32,087,541.00 | 304,859.00 | 99.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 842,600.00 | 537,741.00 | 304,859.00 | 63.8 |
| 210302 | Түлш, халаалт | 31,219,800.00 | 31,219,800.00 | 0.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 330,000.00 | 0.00 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,526,700.00 | 3,563,400.00 | 963,300.00 | 78.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 113,000.00 | 113,000.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,398,900.00 | 435,600.00 | 963,300.00 | 31.1 |
| 210404 | Ном, хэвлэл | 62,800.00 | 62,800.00 | 0.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 315,000.00 | 315,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,137,000.00 | 1,137,000.00 | 0.00 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 23,718,200.00 | 23,661,300.00 | 56,900.00 | 99.8 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,858,600.00 | 1,858,600.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 18,596,700.00 | 18,539,800.00 | 56,900.00 | 99.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,262,900.00 | 3,262,900.00 | 0.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,713,500.00 | 4,712,000.00 | 1,500.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,521,000.00 | 2,520,000.00 | 1,000.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,192,500.00 | 2,192,000.00 | 500.00 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 117,200.00 | 112,000.00 | 5,200.00 | 95.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 117,200.00 | 112,000.00 | 5,200.00 | 95.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,144,600.00 | 1,144,000.00 | 600.00 | 99.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,144,600.00 | 894,000.00 | 250,600.00 | 78.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4235800.00 | 4235500.00 | 300.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,235,800.00 | 2,235,500.00 | 300.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 125600.00 | 125000.00 | 600.00 | 99.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 125,600.00 | 125,000.00 | 600.00 | 99.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 125,600.00 | 125,000.00 | 600.00 | 99.5 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 296,142,000.00 | 277,583,642.00 | 18,558,358.00 | 93.7 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 262,749,600.00 | 244,496,101.00 | 18,253,499.00 | 93.1 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 262,749,600.00 | 244,496,101.00 | 18,253,499.00 | 93.1 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 33,392,400.00 | 33,087,541.00 | 304,859.00 | 99.1 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 33,392,400.00 | 33,087,541.00 | 304,859.00 | 99.1 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 16.00 | 16.00 | 0.00 | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 | 0.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 01.00 | 01.00 | 0.00 | |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 117.00 | 110.00 | 7.00 | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 03.00 | 03.00 | 0.00 | |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 12.00 | 12.00 | 0.00 | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 03.00 | 03.00 | 0.00 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 23,539,739 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 23,539,739 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 23,539,739 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 23,539,739 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 19,045,061 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 4,548,678 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 23,539,739 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 23,539,739 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 23,539,739 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баацагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянговь сумын цэцэрлэгийн эрхлэгч Д. Гансмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-аас 2021 оны 02 дугаар сарын 18–ний хооронд Баянхонгор аймаг дахь Глобал Капитал аудит ХХК-ны газрын аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянговь сумын цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баянговь сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Бага насны хүүхэд бүр бие, оюун ухаан, сэтгэлээр эрүүл өсөн бойжих, өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.гэсэн эрхэм зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай
- Сургуулийн өмнөх боловсролын тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

**3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баянговь сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

**3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 230511,4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4610,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 350522,3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7040,4 мянган төгрөгөөр тооцов.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянговь сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1374867,1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1227936,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн 2020 оны үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 50,168.4 | 60,692.4 | 10,524.0 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 893.1 | 1,520.0 | 626.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 49,275.4 | 59,172.4 | 9,897.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 95,762.6 | 1,314,174.7 | 1,218,412.1 |
| Үндсэн хөрөнгө | 128,481.1 | 1,389,387.3 | 1,260,906.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | (32,718.5) | (75,212.6) | (42,494.0) |
| **Нийт хөрөнгө** | 145,931.0 | 1,374,867.1 | 1,228,936.1 |
| Өр төлбөр | 349.4 | - | (349.4) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 145,581.6 | 1,374,867.1 | 1,229,285.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 145,931.0 | 1,374,867.1 | 1,228,936.1 |

/ Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан/

Бараа материалын дансны үлдэгдэл 59172,4 мянган төгрөг болж 9897,1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тайлант онд 9635,7 мянган төгрөгийн аж ахуйн материалын үлдэгдэл өссөн нь бараа материал дансны үлдэгдлийн өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1389387,3 мянган төгрөг болж 1260906,2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2000,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 1258906,2 мянга төгрөгийн хөрөнгө бүртгэж, авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь нийт 1260906,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгыг Гал хонгор ХХК шинээр барьж 1225149,9 мянган төгрөгөөр ашиглалтад орсон, урсгал төсвийн худалдан авалтаар 2000,0 мянган төгрөгийн гал тогооны хэрэгсэл, БСШУЯ-аас 23236,2 мянган төгрөгийн суурин 3ш компьютер, багш, сурагчдын ширээ сандал, сумын иргэдээс 10520,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга зэрэг хөрөнгө, хандиваар ирсэн нь нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1374867,1 мянган төгрөг болж 1229285,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1229285,5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр 262749,6 мянган 33392,4 төгрөгийн , орон нутгийн төсвөөс 33392,4мянган төгрөгийн,нэмэлт санхүүжилтийн дансаар 23539,7 мянган төгрөгийн, нийт 319681,7 мянган төгрөгийн санхүүжилт авч 18253,5 төвлөрүүлэн бүртгэл тайланд бүрэн зөв тусгасан байна.

Батлагдсан төсөвт нийт зардал 277583,6 мянган төгрөг болж өмнөх оноос 35651.2 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна. Цалин шимтгэлийн зардал 50767,7 мянган төгрөгөөр нэмэгдэж, Цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж цэцэрлэгүүд ажиллаагүйгээс нормативт зардал 12997,0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 358500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 358500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 6706.0 мянган төгрөгөөр бууруулж 296142.0 мянган төгрөгөөр баталсан.

Тайлант онд 3 удаа төсөвт тодотгол хийж 296142,0 мянган төгрөгөөр баталжээ

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 296142,0 мянган төгрөгийн төсөв батласнаас тусгай зориулалтын шилжүүлгээр 262749,6 мянган төгрөгийн,орон нутгийн төсвөөс 33392,4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан ба урсгал үйл ажиллагаанд 277583,6 мянган төгрөгийг зарцуулж 18253,5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 277583,6 мянган төгрөг буюу 93,7 хувьтай байгаа нь цалин хөлс болон урамшууллын зардлыг 13045,1 мянга, нийгмийн даатгалын шимтгэл 4180,0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 304,8 мянга, хангамж бараа материалын зардлыг 963,3 мянга, норматив зардлыг 56,9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 80109 арга хэмжээний тогтмол зардлууд 4952,6 мянган, 81835 арга хэмжээний зардал 6592.8 мянган, 81834, 81833 арга хэмжээний гэрээт ажилтны цалингийн зардал 11770,0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /*хөтөлбөр арга хэмжээгээр*/ мянган.төг

| № | Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | **НИЙТ** | | **296,146.00** | **277,583.60** | **18,562.40** | |
| **1** | **Хөтөлбөр71801** | **Баянговь сумын Цэцэрлэг** | **296,146.00** | **277,583.60** | **18,562.40** | **93.7** |
| **2** | **Арга хэмжээ 80109** | **ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал** | 32392.2 | 28,439.80 | 4,952.60 | **87.8** |
| 3 | 210301 | Гэрэл, цахилгаан | 842.6 | 794.20 | 48.40 | 94.3 |
| 4 | 210302 | Түлш, халаалт | 31219.8 | 26,343.60 | 4,876.20 | 84.4 |
| 5 | 210303 | Цэвэр, бохир ус | 330 | 302.00 | 28.00 | 91.5 |
| 6 | 210604 | Урсгал засвар | 1,000.0 | 1,000.00 | | 100.0 |
| **8** | **Арга хэмжээ 80802** | **Ажил олгогчоос олгох тэтгэмж,** | **125.60** | **125.00** | **0.60** | **99.5** |
| 9 | 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шаг урам | 125.6 | 125.0 | **0.60** | 99.5 |
| **14** | **Арга хэмжээ 81807** | **Цэцэрлэгийн хүүхдийн хоол** | **18,596.70** | **18,539.80** | **56.90** | **99.7** |
| | 210502 | Хоол, хүнс | 18,596.7 | 18,539.8 | **56.90** | 99.7 |
| **14** | **Арга хэмжээ 81832** | **Нүүдлийн бүлэгт хамаарах** | **7,698.40** | **7,578.40** | **120.00** | **98.4** |
| | 210101 | Үндсэн цалин | 7,578.4 | 7,578.4 | **0.00** | 100.0 |
| | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | - | - | **0.00** | 0.0 |
| | 210202 | Тэтгэмжийн даатгал | - | - | **0.00** | 0.0 |
| | 210203 | ҮОМШ-ний даатгал | - | - | **0.00** | 0.0 |
| | 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | - | **0.00** | 0.0 |
| | 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | - | **0.00** | 0.0 |
| | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 120.0 | 120.0 | **0.00** | 100.0 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНХҮҮ...

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | **Арга хэмжээ 81833** | **Явуулын багшийн үйлчилгээ** | **4,935.60** | **111.60** | **4,824.00** | **2.3** |
| 15 | 210101 | Үндсэн цалин | 4,250.2 | - | **4,250.20** | 0.0 |
| 18 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 403.8 | - | **403.80** | 0.0 |
| 19 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 42.5 | - | **42.50** | 0.0 |
| 20 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 34.0 | - | **34.00** | 0.0 |
| 21 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8.5 | - | **8.50** | 0.0 |
| 22 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 85.0 | - | **85.00** | 0.0 |
| 27 | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага х | 111.6 | 111.6 | **0.00** | 100.0 |
| 28 | **Арга хэмжээ 81835** | **Сургалтын хэвийн үйл ажиллагаа** | **32,934.30** | **26,341.50** | **6,592.80** | **80.0** |
| 29 | 210104 | Урамшуулал | 26,042.9 | 21,773.6 | **4,269.30** | 83.6 |
| 30 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 2,213.7 | 618.5 | **1,595.20** | 27.9 |
| 31 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 260.4 | 65.1 | **195.30** | 25.0 |
| 32 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 208.3 | 106.1 | **102.20** | 50.9 |
| 33 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 52.1 | 13.0 | **39.10** | 25.0 |
| 34 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 520.9 | 130.2 | **390.70** | 25.0 |
| 35 | 210402 | Тээвэр, шатахуун | 1,500.0 | 1,500.0 | **0.00** | 100.0 |
| 36 | 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон | 315.0 | 315.0 | **0.00** | 100.0 |
| 37 | 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх | 300.0 | 300.0 | **0.00** | 100.0 |
| 38 | 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,521.0 | 1,520.0 | **1.00** | 99.9 |
| 39 | **Арга хэмжээ 81834** | **Боловсролын стандарт, сургалтыг хэвийн явуулах үйчилгээ** | **198,463.20** | **196,447.50** | **20,828.40** | **99.0** |
| 40 | 210101 | Үндсэн цалин | 105,462.5 | 105,755.7 | **6,804.40** | 100.3 |
| 41 | 210102 | Нэмэгдэл | 54,815.3 | 54,759.8 | **11,770.60** | 99.9 |
| | 210105 | Гэрээт ажлын цалин | 2,000.0 | - | **2,000.00** | |
| 42 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 14,778.3 | 14,008.3 | **770.00** | 94.8 |
| 43 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,602.8 | 1,474.4 | **128.40** | 92.0 |
| 44 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 1,282.2 | 1,179.8 | **102.40** | 92.0 |
| 45 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 320.6 | 294.5 | **26.10** | 91.9 |
| 46 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,205.6 | 2,948.7 | **256.90** | 92.0 |
| 47 | 210401 | Бичиг хэрэг | 113.0 | 113.0 | **0.00** | 100.0 |
| 48 | 210403 | Шуудан, холбоо, интернэт | 1,398.9 | 435.6 | **963.30** | 31.1 |
| 49 | 210404 | Ном, хэвлэл | 62.8 | 62.8 | **0.00** | 100.0 |
| 50 | 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх | 837.0 | 837.0 | **0.00** | 100.0 |
| 51 | 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,858.6 | 1,858.6 | **0.00** | 100.0 |
| 52 | 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,262.9 | 3,262.9 | **0.00** | 100.0 |
| 53 | 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,000.0 | 1,000.0 | **0.00** | 100.0 |
| 54 | 210602 | Тавилга | - | - | **0.00** | #DIV/0! |
| 55 | 210604 | Урсгал засвар | 1,192.5 | 1,192.0 | **0.50** | 100.0 |
| 56 | 210702 | Дотоод албан томилолт | 117.2 | 112.0 | **5.20** | 95.6 |
| 57 | 210801 | Бусад нийтлэг АҮТХураамж | 894.6 | 894.0 | **0.60** | 99.9 |
| 58 | 210802 | Аудит бат, зээрглэл тогтоох | 250.0 | 250.0 | **0.00** | 100.0 |
| | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000.0 | 2,000.0 | **0.00** | 100.0 |
| 59 | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага х | 2,004.2 | 2,004.2 | **0.00** | 100.0 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тэтгэвэрт гарсан Болормаа, Эрдэнэхуяг нарын тэтгэмжид 18991,1 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан Ганчимэгийн тэтгэмжид 4748,7 мянган төгрөгийн орж ирснийг зориулалтын дагуу олгосон байна.

**3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант шилэн дансны цахим хуудсанд хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухай бүр оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан төсвийн хуваарь, аудитын зөвлөмж, зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 3000,0 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроосон, 2 мэдээллийг хугацаа болоогүй учраас мэдээлээгүй байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 3 | 1 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | | 4 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 33 | 3 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 79 | 17 | |
| | Нийт | 27 | 151 | 124 | 25 | 2 |

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлж, 100 хувийн биелэлттэй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1520,0 мянган төгрөгийн, 1 алдаа зөрчил илэрснээс, 3 зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1.1.1.Илрүүлэлт. Тус байгууллага нь 1520,0 мянган төгрөгийн гал тогооны дагалдах хэрэгсэл гэж 2020 оны12-р сарын 21нд Тулга техник ХХК-д мөнгө шилжүүлж, материалыг аваагүй авлага үүсгэсэн байна.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн "6.4.8 төсвийг зохистой удирдаж авлага,өр төлбөр үүсгэхгүй байх. гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*1.1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй*

*1.1.3.Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-т ".төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж, зөрчлийг давтан гаргахгүй, авлага үүсгэхгүй байх.*

*1.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***2.1.1.Илрүүлэлт**: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд боловсруулж мөрдөж ажиллаж байгаа ба тухайн бичиг баримтыг сайжруулах шаардлагатай байна.*

*.Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 8.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.20.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

*нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийн зохион байгуулах" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.*

*2.1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй*

*2.1.3.Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 8.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавapт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.20.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийн зохион байгуулах" гэсэн заалтуудыг мөрдөж баримт бичгийг шинэчлэн сайжруулж, бүртгэлийн бодлоготой уялдуулан, мөрдөж ажиллах шаардлагатай байна.*

*2.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

*3.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

*3.1.1.Илрүүлэлт: Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 124 мэдээллээс хагас жилийн 4 төрлийн 1 мэдээлэл, улирлын 1 төрлийн 4 мэдээлэл, сар бүрийн 3 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр байршуулах 8 төрлийн 17 мэдээлэл, нийт 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.*

*Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.*

*3.1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй*

*3.1.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны сайтад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан хугацаанд мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах*

*3.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

*Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР ............................................................ Д.ЭНХТУЯА

Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР............................................А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР............................................Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.25



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА